



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2019 оны 10 сарын 14 өдөр

Дугаар АБСБ

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 80 дугаар зүйл, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээслэх журам”, нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрмийн 3.4 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын түрээсээр эзэмшүүлсэн байр, талбайн ашиглалтад шалгалт хийх ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, шалгалтын удирдамжийг хоёр дугаар хавсралтаар, шалгалтын зардлыг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Шалгалттай холбоотой гарах зардлыг батлагдсан төсвийн дагуу олгохыг ерөнхий нягтлан бодогч /Н.Уранчимэг/-д зөвшөөрсүгэй.

3. Шалгалтыг хууль, тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулж, дүгнэлт шийдвэр гаргаж танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Д.Төмөрбаатар/-д үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ш.ҮНЭНБАТ

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын даргын 2019 оны 10 дугаар сарын 14 өдрийн 9/38 дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:	Д.Төмөрбаатар	/Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч/
Гишүүд:	М.Мандах	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн дарга/
	Н.Раднаасэд	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн/
	Б.Батаа	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Ц.Цолмон	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Б.Эрдэнэмөнх	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Д.Ганбаяр	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Б.Мөнхбаатар	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/
	Я.Одгэрэл	/Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн мэргэжилтэн/
	Б.Адъяа	/Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн мэргэжилтэн/
Нарийн бичгийн дарга:	Т.Оюунсүвд	/Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын хэлтсийн мэргэжилтэн/

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын
даргын 2019 оны 10 дугаар сарын 14 өдрийн
А/358 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

НИЙСЛЭЛИЙН ӨМЧИТ ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН
ТҮРЭЭСЭЭР ЭЗЭМШҮҮЛСЭН БАЙР, ТАЛБАЙН
АШИГЛАЛТАД ШАЛГАЛТ ХИЙХ ТУХАЙ УДИРДАМЖ

Нэг. Шалгалтын зорилго

НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээслэх журам” –ын хэрэгжилтийн байдалд болон нийслэлийн өмчит төсөвт байгууллагуудын түрээсийн гэрээний хэрэгжилт, зориулалтын дагуу үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нь зөвлөмж өгөхөд оршино.

Хоёр. Эрх зүйн үндэс

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, НИТХТ-ын 2014 оны 65 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчийн эд хөрөнгийн түрээслэх журам”, Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм нь эрх зүйн үндэс болно.

Гурав. Шалгалтын төрөл, хэлбэр

Энэхүү шалгалтыг НӨАУГ-ын даргын 2019 оны 10 дугаар сарын ___ ны өдрийн А/___ дугаар тушаалаар төлөвлөгөөт шалгалтыг дараах хэлбэрээр хийнэ. Үүнд:

- Нийслэлийн өмчит төсөвт байгууллагууд нь өөрийн эзэмшиж буй нийслэлийн өмчийн барилга байгууламжийн илүүдэлтэй байр, талбайг бусдад түрээслүүлэхдээ Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын зөвшөөрөл авсан байх
- Нийслэлийн өмчийн эд хөрөнгийг түрээслэх түрээслэгчийг сонгон шалгуулалт явуулсан байх
- Барилга байгууламжийн илүүдэлтэй байр, талбайг түрээсийн гэрээнд заасан зориулалт, талбайн хэмжээгээр эзэмших
- Түрээсийн төлбөр тооцоо нийлсэн байдал
- Бусдад дамжуулан түрээсэлсэн эсэх
- Эд хөрөнгийг түрээсээр эзэмших хугацаандаа түүний бүрэн бүтэн байдал, урсгал засварын хариуцах, сонгон шалгаруулалтад тавигдсан шаардлагын дагуу ашиглалтыг сайжруулсан байдал зэргийг газар дээр нь шалгах

Дөрөв. Шалгалтын арга

Шалгалтыг баримт бичиг хянан үзэх, байр тайлбайн хэмжилт хийх, шаардлагатай тохиолдолд дүрс бичлэг хийх, гэрэл зураг авах зэрэг аргуудаар хийж гүйцэтгэнэ.

Тав. Шалгалтад хамрагдах байгууллагын нэр

№	Түрээслүүлэгч	Түрээслэх объект	Түрээслэгч	Зориулалт
1	1-р амаржих газар	СБД 1-р хороо 1-р амаржих газар	МӨАУМХолбоо захирал Ш.Хажидмаа	Ажлын байр
2		1-р амаржих газар өргөтгөлийн байрлах хэсэг	Хос мянган ХХК	Кофе шоп
3		1-р амаржих газар	Эко зоог ХХК	Цайны газар
4		СБД 1-р хороо 1-р амаржих газарын блокийн В	Шинээ ЗБН дарга З.Ариунаа	Өвчтөний гал тогоо
5		СБД 1-р хороо 1-р амаржих газар	Ж.Батбаатар	Кофе шоп
6		СБД 1-р хороо 1-р амаржих газар	П.Оюунчимэг	Нярайн хэрэглээний худалдаа
7		СБД 1-р хороо 1-р амаржих газрын өргөтгөлийн хэсэгт байрлах	Монос Улаанбаатар ХХК	Эмийн сан
8		СБД 1-р хороо 1-р амаржих газар	Абико ХХК	Нярайн хэрэглээний худалдаа
9		СБД 1-р хороо 1-р амаржих газар	Ц.Цэрэншиймаа	Нярайн хэрэглээний худалдаа
10		СБД 1-р хороо 1-р амаржих газар	Б.Мягмар	Түргэн үйлчилгээний цэг
11		1-р амаржих газар өргөтгөлийн 1-р давхарт	Бона вита ХХК	Лаборатори
12	БГД 13-р сургууль	БГД 13-р сургуулийн 1-р давхарт байрлах	Ш.Ичинхорлоо	Орон сууц
13	БГД-ийн цагдаагийн 1-р хэсгийн 1-р давхарт байрлана	Энх нандин ХХК	Цайны газар	
14	БЗД 33-р сургууль	БЗД 33-р сургуулийн 1-р давхарт	Э.Эрдэнэтуяа	Бичиг хэргийн худалдаа
15	БНД ЭМН	БНД-ийн ЭМН	Дээрхийн хишиг ХХК	Худалдаа, үйлчилгээ
16	БНД ЭМН	БНД-ийн ЭМН	Иргэн Р.Гантогтох	Сэлбэгийн дэлгүүр

17	Гэрлэх ёслолын ордон	Гэрлэх ёслолын ордны байр	Д.Зоригтбаатар	Үйлдвэрлэл
18	Монголын хүүхдийн ордон	МХО-ны соколд байрлах	В.Ариунбал	Оёдол
19		МХО	Б.Уушаанз	Сургалт
20		МХО 1 дүгээр давхарын 107 тоот өрөө	Н.Мөнхтунгалаг	Ажлын байр
21		МХО 1-р давхарт	Цох сонин	Ажлын байр
22		МХО 1-р давхарт	Монголын хүүхдийн эрхийн төвийн тэргүүн П.Цэвээн	Ажлын байр
23	Нийслэлийн 2-р төрөх	Нийслэлийн 2-р амаржих газар өвчтөний гал тогоо	Элсэн сондор ХХК	Өвчтөний гал тогоо
24		Нийслэлийн 2-р амаржих газар	Нар хүүхдийн өлгий ХХК	Нярайн хэрэглээний худалдаа
25		Нийслэлийн 2-р амаржих газар	Монос Улаанбаатар ХХК	Эмийн сан
26	Нийслэлийн 3-р амаржих газар	Нийслэлийн 3-р амаржих газрын байр	Эммо ХХК	Өвчтөний гал тогоо
27		БЗД-ийн Амгалан амаржих газар	Алим дарь ХХК	Кофе шоп
28		БЗД-ийн Амгалан амаржих газар	Тунгалаг есөн од ХХК	Дэлгүүр
29		БЗД-ийн Амгалан амаржих газар	Бэгдү-Од ХХК	Нярайн хэрэглээний худалдаа
30		БЗД-ийн Амгалан амаржих газар	Монгол эм импекс концерн ХХК	Эмийн сан
31	Нийслэлийн ахмадын хороо	Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ	Төгс илэрхийлэл ХХК	Дэлгүүр
32		Ахмадын хотхон-1 ОНӨААТҮГ	Эрхэстуяа ХХК	Эмийн сан
33	ЧД 24-р сургууль	ЧД 24-р сургууль	Г.Долгорсүрэн	Орон сууц
34	ЧД ЭМН	ЧД ЭМН	Дөш сэнгэ ХХК захирал Л.Отгонбаяр	Буфет
35		ЧД ЭМН	Дөш сэнгэ ХХК захирал Л.Отгонбаяр	Өвчтөний гал тогоо
36		ЧД ЭМН	Анутулга ХХК Б.Оюун-Эрдэнэ	Эмийн сан

Зургаа. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Шалгалтыг 2019 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 2019 оны 10 дугаар сарын 30 - ны өдөр хүртэл

Долоо. Шалгалтын дүнг танилцуулах

Шалгалтын дүнг НӨАУГ-ын Удирдлагын зөвлөлд 2019 оны 11 дүгээр сарын 01 өдөрт багтаан танилцуулна. Шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах, давтан гаргуулахгүй байх арга хэмжээ авч, мэргэжлийн зөвлөгөө өгнө. Шаардлагатай тохиолдолд шалгалтын зөрчлийг хэвлэл мэдээллийн сувгаар олон нийтэд мэдээллэнэ.

Нийслэлийн өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2019 оны 10 дугаар сарын
14 өдрийн 135 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

1119282495 2675589

Зардлын тооцоо

№	Нэрс	Тоо	Нэгжийн үнэ	Бүгд үнэ
1	Шатахуун	50 л	2360	118,000.0
2	Томилолт	10 х/ө	35,500	355,000.0
	Дүн			473,000.0